



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ**

64101 Номгон, Баянхонгор сум
Утас, факс 70-44-00-02

2018.10.05

№

14/526

танай _____ -ны № _____ Т

**Нийцлийн аудитын дүгнэлтийн
мөрөөр авч хэрэгжүүлэх арга
хэмжээний тухай**

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн хурлаар Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас гүйцэтгэсэн “2016, 2017 онуудад төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу явагдсан эсэх”, “Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2017 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”, “Орон нутгийн өмчийн барилга байгууламжийн ашиглалт, хадгалалт хамгаалалтын байдал”-д хийсэн нийцлийн аудитын тайлан, дүгнэлтийг хэлэлцлээ.

Нийцлийн аудитын дүгнэлтийн мөрөөр дараах ажил, арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай байна. Үүнд:

1. Аймгийн хэмжээнд Татварын хэлтэс, Авто тээврийн үндэсний төв, Цагдаагийн газруудад бүртгэлтэй автомашинуудын тоо зөрүүтэй байгаа зөрчил дутагдлыг арилгаж, “Автомашин нэгдсэн бүртгэл” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж, үр дүнг танилцуулах

2. Нийцлийн аудитын дүгнэлтээр холбогдох хууль тогтоомж зөрчсөн, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, хариуг ирүүлээгүй албан тушаалтнуудад хариуцлага тооцож, хариу ирүүлэх цаашид хууль тогтоомжийг мөрдөж, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах

3. Баянхонгор сумд баригдаж байгаа 5 дугаар арван жилийн барилгын ажлыг гүйцэтгэж байгаа, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй аж ахуйн нэгжийг холбогдох яаманд асуудал тавьж, шүүхээр асуудлыг шийдүүлэх

4. Аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргад худалдан авах ажиллагааны улсын байцаагчийн эрх олгох хүсэлтийг Сангийн яаманд тавьж шийдвэрлүүлэх

5. Улсын болон орон нутгийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлтийг сайжруулах, Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан журмыг хэрэгжүүлж ажиллах цаашид төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах, зураг төсөв, тооцоо судалгаатай ажлыг санхүүжүүлж ажиллах

6. Улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй бараа, ажил үйлчилгээний эцсийн санхүүжилтийг ажил үйлчилгээ үнэн зөв, чанартай хийгдсэн эсэх, холбогдох байгууллагын санал, дүгнэлт гарсаны дараа эцсийн санхүүжилтийг олгож байх

7. Нийцлийн аудитын дүгнэлтээр өгсөн хугацаатай зөвлөмжүүдийн хэрэгжилтийг гаргаж зөвлөмжийн мөрөөр тодорхой үр дүн гаргаж ажиллах

8. Шинээр барилга байгууламж барихдаа хуучин барилга, байгууламжийг ямар нэг зөвшөөрөлгүйгээр дур мэдэн буулгаж, худалдан борлуулдаг, борлуулалтын орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлдэггүй, аж ахуйн нэгж, иргэн завшдаг асуудлыг зогсоож, буруутай этгээдээр нөхөн төлүүлэх

Дээрх ажил, арга хэмжээний талаар авч хэрэгжүүлсэн тайлан, мэдээллийг 2018 оны 12 дугаар сарын 20-ны дотор аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн хуралд танилцуулна уу.

